22.	3.3	"Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх" стандартын төслийг Стандарт хэмжилзүйн газраар батлуулах.	Төслийн хэлэлцүүлэг хийсэн эсэх, Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулсан эсэх,	II-IV улирал	"Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх" стандартын төслийг боловсруулж, ИНҮТ-ийн даргын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 09-1/1181 дугаартай албан бичгээр ИНЕГ-ын Бодлогын хэрэгжилтийн хэлтэст хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** ИНЕГ-тай хамтран төслийн хэлэлцүүлэг зохион байгуулна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** ЗТЯ-нд хэлэлцүүлэг зохион байгуулна. **IV улиралд:** Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлж батлуулсан байна.	Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх Стандартын төслийг боловсруулан "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.09.16-ны өдрийн 01-4/1338 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хэлэлцүүлэг зохион байгуулах тухай албан хүсэлт хүргүүлсэн. "Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх стандартын төсөл"-ийг ИНЕГ дээр журам болгон үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр шийдвэрлэж, ИНЕГ-ын даргын 2025.12.09-ний өдрийн А/349 дүгээр тушаалаар "Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх журам"-ыг баталсан. Иймд дээрх төслийг стандарт болгох шаардлагагүй болсон. Хавсралт: "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.09.16-ны өдрийн 01-4/1338 дугаартай албан бичиг, ИНЕГ-ын даргаар батлагдах "Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх журам"-ын төсөл, ИНЕГ-ын даргын 2025.12.09-ний өдрийн А/349 дүгээр тушаалаар баталсан "Аэродромын хучилтын ашиглалтын нөхцөлийг үнэлэх журам"-ыг тус тус хавсаргав.	НБҮГ	100
23.	3.4	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөөний	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Ерөнхий зориулалтын хөгжүүлэх төлөвлөгөөг ЗТЯ-ны Төрийн нарийн	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30	Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, ИНҮТ-ийн даргаар 2024.09.06-ны өдөр батлуулсан.	НБҮГ	75

		2025 оны хэрэгжилтийг хангах.			бичгийн даргаар 2024.08.20-ны өдөр батлсан. Батлагдсан төлөвлөгөөг үндэслэн "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө"-г ИНҮТ-ийн даргаар 2024.09.06-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 76 хувьтай.	хувьд хүргэсэн байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар: III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	ЗТСайдын 2024.12.27-ны өдрийн А/290 тоот тушаалаар "ИНҮТ" ТӨХХК болон өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор нэгжүүдийн чиг үүргүүд өөрчлөгдсөн тул ИНЕГ болон "ИНҮТ" ТӨХХК хамтарсан уулзалт хийж, Ерөнхий зориулалтын батлагдсан төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2025.05.13-ны өдрийн 01-5/641 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. Шинээр ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөө батлагдсаны дараа хэрэгжүүлэх тул хойшлуулсан. Хавсралт: ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.08.20-ны өдөр баталсан Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх төлөвлөгөө, ИНҮТ-ийн даргын 2024.09.06-нд баталсан Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө, 2025.05.13-ны өдрийн 01-5/641 дугаартай албан бичгийг тус тус хавсаргав.		
24.	3.5	Орон нутгийн зарим аэродромын даац /PCN/-ыг PCR аргачлалаар аэродромын тооцооллыг хийх.	Аэродромын даац /PCN/-ыг PCR болгох тооцооллыг хийсэн эсэх	I-III улирал	Иргэний нисэхийн олон улсын байгууллагын Хавсралт 14-ийн дагуу аэродромын даацыг PCN аргачлалаар тодорхойлсон.	**Хагас жилийн байдлаар: I улиралд:** PCR аргачлалаар аэродромын тооцоолол хийх жагсаалтыг хийсэн байна. **II улиралд:** 1 аэродром **Жилийн эцсийн байдлаар: III улиралд:** 1 аэродром	2025 онд Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух зурвасын засвар, Өндөрхаан нисэх буудлын апрон шинээр ашиглалтад орж буйтай холбогдуулан аэродромын даац /PCN/-ыг PCR болгох тооцооллыг хийх нисэх буудлуудыг шинээр тодорхойлсон. 1.Гурвансайхан нисэх буудлын хөөрч буух зурвасын тооцоолол 100%-ийн гүйцэтгэлтэй байна. 2.Өндөрхаан нисэх буудлын апрон талбайн тооцоолол 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт: Гурвансайхан Өндөрхаан НБ-ын апронд тооцоолол хийсэн баримтыг хавсаргав.	НБҮГ	100
25.	3.6	"Чингис хаан" олон улсын нисэх буудалд "Шатахуун хангамжийн байгууламж"	Ажил эхэлсэн эсэх,	I-IV улирал	62а, 62б, 62в дугаар талбар газрыг холбогдох хуулийн этгээдүүдэд олгосон.	**Хагас жилийн байдлаар: I-II улиралд:** Улсын тусгай хэрэгцээний газар ашиглагч хуулийн	Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2025.02.11-ний 07/121 тоот албан бичгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу газрын дуудлага худалдаа зохион байгуулж, агаарын тэзврийн барилга, байгууламж,	НБҮГ	30

		байгуулах ажлыг эхлүүлэх. (Хяналтаас хасуулах санал гаргах)				этгээдүүдэд ажлын даалгаврыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Хуулийн этгээдүүдтэй хэлэлцээ хийж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана.	төхөөрөмжийн талбай зориулалттай 3954 м2 газрыг "Сод Монгол Групп" ХХК-д, 4022 м2 газрыг "Интерстандарт Нефть" ХХК-д тус тус олгосон талаар мэдээлсэн. Энэ хүрээнд ЗТС-ын 2025.02.14-ний өдрийн 09/703 дугаартай албан бичгээр дээрх компаниудад "Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь агаарын хөлгийн Жет А-1 төрлийн шатахуун хангамжийн агуулах"-ын **ажлын даалгаврыг хүргүүлж, төслийг хэрэгжүүлэх тооцоо, судалгааг боловсруулж ирүүлэх талаар мэдэгдэл хүргүүлсэн**. Монгол Улсын Засгийн Газрын 2025.03.06-ны өдрийн 116 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.03.20-ны өдрийн 136 дугаартай тогтоолуудыг үндэслэн ИНЕГ-ын даргын 2025.03.24-ний өдрийн А/75 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Шатахуун хангалтын албыг ИНЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 54,807,988,166.68 төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн хамт "Эрчис Ойл" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид 2025.03.31-ний өдөөр тасалбар болгон шилжүүлэн хүлээлцсэн. Иймд гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.6 дахь ажлыг хяналтаас хасуулах саналтай байна. Хавсралт: Монгол Улсын Засгийн Газрын 2025.03.06-ны өдрийн 116 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025.03.20-ны өдрийн 136 дугаартай тогтоол, ИНЕГ-ын даргын 2025.03.24-ний өдрийн А/75 дугаартай тушаалыг тус тус хавсаргав.		
26.	3.7	"Чингис хаан" олон улсын нисэх буудалд "airport hotel" байгуулах ажлыг эхлүүлэх.	Санал боловсруулж хүргүүлсэн эсэх	**I-II** улирал	Газрын асуудлыг шийдвэрлэсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** "Airport hotel"-ын ажлын даалгаврыг боловсруулах ажилд холбогдох дэмжлэг	"Чингис хаан" олон улсын нисэх буудлыг түшиглэн байгуулахаар төлөвлөж буй "airport hotel"-ын ажлын даалгаврыг боловсруулах ажилд холбогдох дэмжлэг үзүүлэх саналыг гүйцэтгэх захирлын 2025.04.22-ны өдрийн 01-5/477 дугаартай албан бичгээр ИНЕГ-т хүргүүлсэн.	БТГ	100

						үзүүлэх саналыг төслийг ИНЕГ, ЗТЯ-нд хүргүүлнэ.	Зам, тээврийн сайдын 2025.05.23-ны өдрийн 01/2374 дугаар албан бичгээр "Аэрпорт зочид буудал" байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулахыг "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал"-д чиглэл өгсөн. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.04.22-ны өдрийн 01-5/477 дугаартай албан бичиг, Зам, тээврийн сайдын 2025.05.23-ны өдрийн 01/2374 дугаар албан бичгийг тус тус хавсаргав.		
27.	3.8	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах ажлыг эхлүүлэх.	Ажлын гүйцэтгэл, хувиар	I-II улирал	Төслийг ИНЕГ-аас 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 02/2643 дугаар албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Хөрөнгө оруулалт татах чиглэлээр ерөнхий судалгааг хийж, ИНЕГ-т хүргүүлсэн байна.	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн НҮБ-ийн Дэлхийн Хүнсний хөтөлбөрийн хүрээнд Хүмүүнлэгийн тусламжийн хариу арга хэмжээний төв байгуулах зорилгоор Зам, тээврийн сайдын 2025.03.20-ны өдрийн 03/1226 дугаартай албан бичгээр Батлан хамгаалах яамтай хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд хариу 1в/1445 дугаартай албан бичиг ирүүлсэн. Хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулахад Гадаад харилцааны яам, Эрүүл мэндийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, НҮБ-ын суурин төлөөлөгчийн газруудтай хамтран ажиллах шаардлагатай гэсэн хариуг ирүүлсэн. Иймд "ИНҮТ" ТӨХХК нь ЗТЯ-нд 2025.09.03-ны өдрийн 01-5/1271 тоот албан бичгээр "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг түшиглэн НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн төв байгуулах тухайд чиглэл өгөх хүсэлт албан бичиг илгээсэн бөгөөд одоогоор хариу өгөөгүй байна. Хавсралт: БХЯ-аас 2025.04.23-ны өдөр ирүүлсэн 1в/1445 дугаартай албан бичиг, "ИНҮТ" ТӨХХК нь ЗТЯ-нд 2025.09.03-ны өдрийн 01-5/1271 тоот албан бичгийг тус тус хавсаргав.	НБҮГ	100
28.	3.9	Хэнтий аймаг дахь "Өндөрхаан	Ажлын гүйцэтгэл хувиар,	I улирал	1.Зорчигч үйлчилгээний	**Хагас жилийн байдлаар:**	Хэнтий аймгийн "Өндөрхаан" нисэх буудлын шинэ барилгыг Хот байгуулалт, барилга	НБҮГ ХААА	100

		нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийн хэрэгжилтэд хяналт тавих.			барилга, автомашины гараааш, дизелийн байрны ажлын гүйцэтгэл 88.5 хувьтай. 2.Хөөрч буух шороон зурвасын ажил 100 хувьтай, гэрэл суултын системийн ажил 67 хувьтай байна. 3. Тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна.	**I улиралд:** Зорчигч үйлчилгээний байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авна.	орон сууцжуулалтын сайдын 2025.05.02-ны өдрийн 97 дугаар тушаалаар байгуулагдсан 9 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025.05.08-ны өдөр ажиллаж, дүгнэлтийг /актыг/ 2025.05.28-ны өдөр үйлдэж, ашиглалтад оруулах шийдвэр гаргасан. Барилгын явцад техник, технологийн хяналтыг бүрэн хэрэгжүүлсэн. Хавсралт: 2025.05.28-ны өдрийн Барилга байгууламжийн ашиглалтад оруулсан комиссын дүгнэлтийг хавсаргав.		
29.	3.10	"Шинэ Хархорум" хотод олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын "4E" ангилал бүхий нисэх буудал байгуулах ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах.	ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэлээр	I-IV улирал	Цаг уурын автомат станц суурилуулан салхи, уур амьсгалын судалгаа хийж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	"Хархорум хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар"-ыг ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга нар 2025.04.10-ны өдрийн 06/2025/08 тоотоор батлалсан. "Шинэ Хархорум" хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг /ХББОСЯ/20250103056 дугаар/ 2025.05.29-ний өдөр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,197,500 мянган төгрөгийн нийт төсөвт өртөгтэйгөөр зарласан. Тендерийг 2025.06.27-ны өдөр нээсэн боловч "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 13.1.2 дахь заалтын дагуу зогсоосон. ЗТЯ-аас 2025.08.11-ний өдрийн 09/3617 дугаартай "Хархорум хотын захирагчийн албаны хүсэлтээр хамтран ажиллах тухай" албан бичгийн дагуу уулзалт зохион байгуулсан.	НБҮГ БТГ ХААА	100

							"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.09.16-ны өдрийн 01-4/1349 дугаартай албан бичгээр компанийн зүгээс шаардлагатай ЗТЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга нар 2025.04.10-ны өдрийн 06/2025/08 тоотоор баталсан "Хархорум хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар" болон судалгааны ажлын баримт бичгүүдийг ЗТЯ болон Хархорум хотын ажлын албанд хүргүүлсэн. Хавсралт: 2025.04.10-нд баталсан "Хархорум хотын олон улсын нисэх онгоцны буудлын ТЭЗҮ, барилгажилтын төсөл, аэродромын ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар", ЗТЯ-ны 2025.08.11-ний өдрийн 09/3617 дугаартай албан бичиг, "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.09.16-ны өдрийн 01-4/1349 дугаартай албан бичгийг тус тус хавсаргав.		
30.	3.11	"Дэлүүнболдог" нисэх буудлын барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, цаашдын ашиглалт, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах.	Ажлын гүйцэтгэл хувиар. Цаашдын ашиглалт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан эсэх	I-IV улирал	Барилгын ажлын гүйцэтгэгч "Биг монголиа биүлдинг" ХХК-ийн гүйцэтгэл 98 хувьтай нэмэлт гэрээ байгуулсан "Барилга эрч" ХХК-ийн гүйцэтгэл 3%-тай байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** • Гүйцэтгэгч компанитай нэмэлт гэрээ байгуулж, графикийг тодотгоно. • Дулааны улиралд барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана. **II улиралд:**	Энэ төсөл нь 2 хэсгээс бүрддэг. 1. Барилгын эхний хэсгийг "Биг Монголиа" ХХК гүйцэтгэсэн. 2024.12.23-ны өдрийн 01/2024 дугаартай барилга байгууламжийг хүлээж авах комиссын дүгнэлтээр 100 хувь хүлээн авч гэрээг 2025.06.09-ний өдөр эцэслэн дүгнэсэн. 2. Барилгын 2 дахь хэсгийн ажлыг "Барилга эрч" ХХК гүйцэтгэж байна. Гэрээний дагуу ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх хугацаа 2024.12.20-ны өдөр байсныг ЗТЯ-с 2025.01.14-ний өдөр №УТ2002800921/31 тоот гэрээ байгуулан дуусах хугацааг 2025.07.30 болгож өөрчлөлт оруулан графикийг тодотгосон байсныг ЗТЯ дээр 2025.08.13-ны өдөр гэрээг дүгнэн 2025.08.15-ны өдөр №205 дугаартай нэмэлт	НБҮГ ХААА /БХХАГ/	72,5

						Зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 хувьд хүрсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан байна. Цаашдын ашиглалтын санал боловсруулан судалгаа хийж, "ИНҮТ" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захиралд танилцуулсан байна.	гэрээ байгуулан ашиглалтад өгөх хугацааг 2025.11.30 өдөр хүртэл сунгасан. 2025.12.01-ний өдрийн байдлаар "Барилга эрч" ХХК-ийн гэрээт ажлын баталгаажсан гүйцэтгэлээр нийт 3,638,211,257 /3,6 тэрбум/ төгрөгийн санхүүжилт олгоод байна. Барилга угсралтын ажлын /гэрээ байгуулсан тоо хэмжээгээр/ гүйцэтгэл 95 хувьтай байна. Дэлүүнболдог нисэх буудлын хөөрч буух шороон зурвасыг өргөтгөх боломжтой эсэх нисэхийн судалгаа хийсэн ажлын тайланг НБҮГ-ын даргын 2025.12.09-ний өдрийн 287 дугаартай "Дэлүүнболдог нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөлтийг тодорхойлж өгөх хүсэлт"-ийг албан бичгээр БТГ-т хүргүүлсэн. Хавсралт: 2024.12.23-ны өдрийн 01/2024 дугаартай комиссын дүгнэлт,/2005.06.09/ , ЗТЯ-ны 2025.01.14-ний өдрийн №УТ2002800921/31 дугаар гэрээ, ЗТЯ-ны 2025.08.15-ны өдөр №205 дугаартай нэмэлт гэрээ, НБҮГ-ын даргын 2025.12.09-ний өдрийн 287 дугаартай албан бичиг, судалгааг тус тус хавсаргав.		
31.	3.12	Орон нутгийн зарим нисэх буудлуудын хөөрч буух зурвас, аэродромд засвар хийх.	Хөөрч буух зурвас, аэродромд засвар хийсэн эсэх	I-IV улирал	2024 оны урсгал зардал болон өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөвт Булган сум /Ховд/, Дэлүүнболдог нисэх буудлуудын хөөрч буух зурвас, аэродромд засвар хийх ажлуудын хөрөнгө батлагдаагүй. 2025 оны төсвийн	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Булган сум /Ховд/, Дэлүүнболдог нисэх буудлын аэродромын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Булган сум /Ховд/, Дэлүүнболдог нисэх	1.Сангийн Сайд, Зам тээврийн Сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "ИНҮТ" ТӨХХК-ийн 2025 оны урсгал зардал болон өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсөвт Булган сум /Ховд/, Дэлүүнболдог нисэх буудлуудын хөөрч буух зурвас, аэродромд засвар хийх ажлуудын хөрөнгө батлагдаагүй тул "ИНҮТ" ТӨХХК-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд суугаагүй тул дүгнэх боломжгүй, хяналтаас хасуулах саналтай байна. Отгонтэнгэр, Алтай, Гурвансайхан НБ-ын хөөрч буух зурвас, аэродромд засварын ажлууд "ИНҮТ" ТӨХХК-ийн 2025 оны	НБҮГ ХААА	70

					саналд санал хүргүүлсэн.	буудлын аэродромын засварын ажлыг гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.	худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан. Гурвансайхан НБ-ын хөөрч буух зурвас, аэродромд засварын ажлын тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Чамбай зам" ХХК шалгарч, 2025.04.21-ний өдөр ИНҮТ/ХО/20250101008 дугаартай гэрээг байгуулан 2025.04.22-ны өдрөөс ажил эхлэн 2025.06.16-ны өдөр Улсын комисс хүлээн авсан. Отгонтэнгэр, Алтай, Гурвансайхан НБ-ын хөөрч буух зурвас, аэродромд засварын ажлуудыг орон нутагт эрх шилжүүлсэн. Хавсралт: 2025.06.16-ны өдөр Улсын комисс хүлээн авсан акт хавсаргав.		
32.	4.1	"Иргэний нисэхийн аюулгүй хамгаалалт"-ын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөөг батлуулсан эсэх. Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар,	I-IV улирал	Төлөвлөгөөг боловсруулж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөө батлуулсан байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 20 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна	Нисэхийн аюулгүйн хамгаалалтын газрын 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, хянаж, Үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан ерөнхий менежерээр 2025.04.21-ний өдөр батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын газрын 2025 оны төлөвлөгөөнд хэрэгжүүлэх 24 арга хэмжээ төлөвлөснөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 95,4%-тай байна. Хавсралт: Иргэний нисэхийн аюулгүй хамгаалалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав.	НАХГ	95,4
33.	4.2	АНУ-ын нислэг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулж, шаардлагатай	Өөрчлөлт оруулсан баримт бичгийн тоо, Судалгаа хийсэн эсэх	I-III улирал	НАБХА-ны Аюулгүйн хамгаалалтын ерөнхий зааварт 2024 онд нийт 5 удаа нэмэлт	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** АНУ-ын Тээврийн аюулгүй байдлын захиргааны Үйл ажиллагааны заавар	АНУ-ын TSA-ны Үйл ажиллагааны заавар (SOP)-аас холбогдох хэсгийг Нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын албаны "Аюулгүйн хамгаалалтын ерөнхий заавар"-т нэмэлт өөрчлөлтөөр тусган боловсруулж, "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын	НАХГ	100

							ИНЕГ-ын 2025.05.05-ны өдрийн 01/750 дугаартай албан бичиг, Гүйцэтгэх захирлын 2025.03.28-ны өдрийн А/157 дугаар тушаал, НАХГ-ын орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага, Монгол Улсын ерөнхий сайдын 2025.06.18-ний өдрийн 01 дүгээр албан даалгавар, Монгол Улсын ерөнхий сайдын 2025.07.25-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврыг тус тус хавсаргав.		
34.	4.3	АНУ-ын нислэг эхлүүлэхтэй холбоотойгоор ажилтнуудыг сургалтад хамруулах.	Сургалтад хамруулсан ажилтны тоо	I-II улирал	АНУ-ын Тээврийн аюулгүй байдлын захиргаанаас 2024 онд 26 ажилтныг аюулгүй байдлын сургалтад хамруулсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** АНУ-ын Тээврийн аюулгүй байдлын захиргаанаас "Чингис Хаан" ОУНБ-ын Олон улсын зорчигчийг шалгах А-21 үзлэгийн цэгт шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх сургалтад ажилтнуудыг хамруулсан байна.	Монгол улс АНУ-ын хооронд шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2025.03.19-өөс 21-ний өдрүүдэд Аюулгүйн үзлэгийн 60 ажилтанд "Зөвшөөрөгдөөгүй эд зүйлс бодитоор таниулах, Биет үзлэг" сэдэвт ажлын байрны сургалтыг тус тус зохион байгуулсан. 2025.03.19, 21-ний өдрүүдэд Үзлэг шалгалтын хэсгийн 42 ажилтанд "Itemiser-5X dual view рентген аппарат"-ны сургалтыг зохион байгуулсан. 2025.04.26-наас 2025.05.01-ний өдрийн хооронд United Airlines компанийн багш нар аюулгүйн хамгаалалтын 97 ажилтанд карго, катеринг, агаарын хөлгийн гадна болон дотор талын үзлэг сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн нислэгийн ачаалал, ажилтнуудын зэлжийн амралт зэргээс шалтгаалан Юнайтэд Эйрлайнс компанийн Агаарын хөлгийн дотор болон гадна үзлэгийн сургалтыг дахин 2025.08.21-ний өдөр зохион байгуулж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын 17 ажилтнууд шинээр хамрагдсан. United Airlines компанийн сургалтад нийт 114 ажилтныг хамруулсан. Хавсралт: UA-тай байгуулсан "Зорчигчийн аюулгүй байдлын үзлэгийн үйлчилгээний хураамж төлөх гэрээ", Сургалтад хамрагдсан ажилтнуудын жагсаалтыг тус тус хавсаргав.	НАХГ	100

35.	5.1	Олон улсын нисэх буудлуудын зөвлөл (ACI)–тэй хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөө батлуулсан эсэх. Хэрэгжилт хувиар	I-IV улирал	2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 70%-тай байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	ИНҮТ болон олон улсын нисэх буудлуудын зөвлөлийн хамтын ажиллагааны чиглэлээр 2024-2026 онуудад хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг 2024 онд батлагдсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан 2025.03.17-ны өдөр "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 98.5%-тай байна. Хавсралт: 2025.03.17-нд батлагдсан төлөвлөгөө, Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.	БТГ АНҮГ	98,5
36.	5.2	"ИНҮТ" ТӨХХК-ийн бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулах.	Бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан эсэх Төлөвлөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	ИНҮТ-ийн Бизнес төлөвлөгөөг боловсруулж, ИНҮТ-ийн даргад танилцуулахаар хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** 2024.1 дүгээр сард Бизнес төлөвлөгөөг боловсруулж, ТУЗ-д хүргүүлж, батлуулсан байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70	"ИНҮТ" ТӨХХК-ийн 2024-2028 оны "Бизнес төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж, гүйцэтгэх захиралд танилцуулсан. Гүйцэтгэх захирлын 2025.06.04-ний өдрийн А/335 дугаар тушаалаар "2025 оны Бизнес төлөвлөгөө", эдийн засгийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, танилцуулах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгээс "ИНҮТ" ТӨХХК-ийн 2024-2028 оны "Бизнес төлөвлөгөө"-г захирлын зөвлөл болон ТУЗ-д танилцуулах шаардлага хангаагүй тул зөвлөх үйлчилгээ авч хамтран боловсруулах нь зүйтэй." гэсэн шийдвэр гарсан. Иймд "ИНҮТ ТӨХХК-ийн 2026-2030 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө"-г боловсруулан батлуулах, үүний дараа компанийн "ИНҮТ" ТӨХХК-ийн "Бизнес	БХХАГ БТГ	50

						хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьд хүргэсэн байна.	төлөвлөгөө"-г батлуулах шаардлагатай гэж үзсэн. "ИНҮТ" ТӨХХК-ийн 2026-2030 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төслийг 2025.12.04-ний өдөр ИНҮТ-ийн удирдлагын хурлаар хэлэлцэж, хурлаас стратеги төлөвлөгөөний төслийг ТУЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэсэн. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.06.04-ний өдрийн А/335 дугаар тушаал, Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус хавсаргав.		
37.	5.3	Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний байгууллага *(CANSO)*–тай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах.	Төлөвлөгөө батлуулсан эсэх, Хэрэгжилт, хувиар	I-IV улирал	2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 70%-тай байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэсэн байна.	Иргэний нисэхийн агаарын навигацийн үйлчилгээний байгууллага (CANSO)-ын хамтын ажиллагааны чиглэлээр 2024-2026 онуудад хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө 2024 онд батлагдсан. Энэхүү төлөвлөгөөний дагуу 2025 хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан 2025.03.14-ний өдөр гүйцэтгэх захирлаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд нийт 6 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй байна. Хавсралт: 2025.03.14-ний өдөр Гүйцэтгэх захирлаар батлуулсан 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус	БТГ БХХАГ	95
38.	5.4	Нийтийн мэдээллийн ил тод байдал ба	Компанийн албан ёсны вэбсайт,	I-IV улирал	ИНЕГ-ын, албан ёсны вэбсайт, цахим хуудсанд	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:**	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байгууллагын	ЗСУГ	70

		мэдээлэл авах эрхийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх.	цахим хуудсыг шинэчилсэн эсэх, Мэдээллийг байгууллагын цахим хуудаст хуулийн холбогдох заалтын дагуу бүрэн оруулсан эсэх, Мэдээллийн хэрэгжилт хувиар		2024 онд тус төвд хамааралтай нийт 1541 мэдээ мэдээлэл байршуулж, олон нийтэд түгээсэн.	Компанийн албан ёсны вэбсайт, цахим хуудсыг шинэчлэнэ. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулна. Мэдээллийн хэрэгжилтийг 30% хувьд хүргэсэн байна **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Мэдээллийн хэрэгжилтийг 70% хувьд хүргэсэн байна **IV улиралд:** Мэдээллийн хэрэгжилтийг 90% хувьд хүргэсэн байна	цахим хуудас, самбарт байршуулж, олон нийтэд мэдээлэх, сайтаар тайлагнах. Компанийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан нээлттэй мэдээллийг компанийн цахим хуудсанд байршуулах, нийтлэхтэй холбогдуулан цахим хуудасны программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэн 2025.04.15-ны өдөр ашиглалтад оруулсан. 2. Үүний дагуу тус компанид хамааралтай 60 нээлттэй мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах, нийтлэх, шинэчлэх, өөрчлөх ажлыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн, shilen.gov.mn сайтад тайлагнасан бөгөөд 2025 оны 2 дугаар улиралд 62%, 3 дугаар улиралд 60%-тай тайлан баталгаажсан. 3. Мөн цахим хуудасны байнгын үйл ажиллагааг хангах журмыг боловсруулж, гүйцэтгэх захирлын 2025.05.08-ны өдрийн А/294 дугаар тушаалаар баталсан. 4. Тус компанид хамааралтай мэдээ мэдээллийг компанийн www.ncac.mn цахим хаяг болон мэдээллийн самбарт хуульд заасан хугацаанд нь нийтлэх, шинэчлэх, засварлах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангуулах үүрэг бүхий албан тушаалтны жагсаалтыг батлахаар ажиллаж байна. 2025 оны 4-р улирлын байдлаар мэдээллийн хэрэгжилт баталгаажиж ирээгүй байна. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.05.08-ны өдрийн А/294 дугаар тушаалыг хавсаргав.		
39.	5.5	ГТҮШХА-ны парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр	Эдийн засгийн үр ашгийн тооцоог боловсруулсан эсэх,	I-IV улирал	ГТҮШХА-нд парк шинэчлэл хийхэд шаардлагатай авто машины судалгаа,	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:**	Суурь судалгаанд үндэслэн парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр ашгийн анхан шатны тооцоо, төслийг 2025.02.07-ны өдөр боловсруулж, танилцуулан дахин	БХХАГ	70

		ашгийн тооцоог боловсруулж, төсөл боловсруулах.	Төсөл боловсруулсан эсэх. Төслийг Иргэний нисэхийн үндэсний төвийн даргаар батлуулсан эсэх, Төслийг ТУЗ-д хүргүүлсэн эсэх,		хүчин чадал, техникийн чадавхыг судлан 2024.12.02-ны өдөр ИНҮТ-ийн даргад танилцуулсан.	Парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр ашгийн тооцоог боловсруулж, төслийг боловсруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд** Төслийг "ИНҮТ" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлаар батлуулж, ТУЗ-д хүргүүлсэн байна.	шинэчлэл хийж, 2025 оны 5 дугаар сард гүйцэтгэх захиралд танилцуулсан. Хавсралт: Суурь судалгаанд үндэслэн парк шинэчлэлийг хийх эдийн засгийн үр ашгийн анхан шатны тооцоо, төслийг хавсаргав.		
40.	5.6	"Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын ажлын даалгавар, зургийн даалгаврыг эскиз зургийн хамт боловсруулах.	Барилгын ажлын даалгавар боловсруулсан эсэх. Зургийн даалгавар боловсруулсан эсэх, Эскиз зураг боловсруулсан эсэх, Төсвийг 2026 оны хөрөнгө оруулалтын саналд тусгуулсан эсэх,	I-IV улирал	Барилга барих газрыг сонгож бэлэн болгосон байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** "Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын ажлын даалгавар боловсруулсан байна. **II улиралд:** "Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны зургийн даалгавар боловсруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** "Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын зургийн эскиз зургийг боловсруулсан байна.	"Буянт-Ухаа" академийн ажлын даалгавар, зургийн даалгаврыг эскиз зургийн хамт боловсруулах ажил "ИНҮТ" ТӨХХК-ийн 2025 оны хөрөнгө оруулалтад "Сургалтын төвийн зураг төсөл" нэртэйгээр 300,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр батлагдсан. "Буянт-Ухаа" академи /Сургалтын төв/-ийн зураг төсөл, ажлын даалгавар, ерөнхий эскиз зургийн хамт 2025.03.20-ны өдөр, "Ахмадын өргөө" цогц барилгын зураг төсөв, ажлын даалгавар, ерөнхий скиз зургийн хамт 2025.06.18-ны өдөр тус тус батлуулсан. "Буянт-Ухаа" академи /Сургалтын төв/-ийн зураг, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулан 2025.04.30-ны өдөр "Гипотенуз дизайн" ХХК-тай гэрээг байгуулж, ажил гүйцэтгэж байна. "Ахмадын өргөө"-ний барилгын зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулсан. Шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул дахин зарлахаар ажиллаж байна.	БХХАГ ХАААБТГ	80

						IV улиралд: "Буянт-Ухаа" академи болон Ахмадын хорооны барилгын төсвийг 2026 оны хөрөнгө оруулалтын саналд тусгуулсан байна.	Тайлбар: "Жаргалант" сэргээн засах амралтын газрын газар эзэмших эрх нь ИНЕГ дээр байгаа бөгөөд газрын эрх дууссан. ИНЕГ-аас Байгаль орчин аялал жуулчлалын яаманд газрын гэрчилгээ сунгах хүсэлтийг хүргүүлсэн. Газрын гэрчилгээ сунгагдсаны дараагаар Нийслэлийн архитектур төлөвлөлтийн газар хүргүүлж, архитектур төлөвлөлтийн даалгаврыг авч гүйцэтгэгч болох "Гиптнок дизайн" ХХК-д хүргүүлэн зургийг ажлыг хүргүүлнэ. Одоогоор тус гэрээт ажлын гэрээний хугацааг сунгасан байгаа. Ахмадын өргөөний барилгын ажлын зураг төслийн хувьд 2025.06.18-ны өдөр зургийн даалгаврыг гүйцэтгэх захирлаар батлуулан зургийн ажлын тендер сонгон шалгаруулалтыг зарласан. ХОЗА-нд нийт 4 удаа тендер шалгаруулалт зарласан боловч тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна. Дахин тендер шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.03.20-ны өдөр баталсан "Сургалтын төвийн зураг төсөл, ажлын даалгавар", Гүйцэтгэх захирлын 2025.06.18-ны өдрийн "Ахмадын өргөө"-ний ажлын даалгавар, Гүйцэтгэх захирлын 2025.05.08-ны өдрийн А/283 дугаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" тушаал, Гүйцэтгэх захирлын 2025.04.30-ны өдрийн 01-9/551 дугаартай "Гэрээ байгуулах эрх олгох тухай " албан бичиг, ИНЕГ-т 2025.08.08-ны өдрийн 01/1284 дугаартай албан бичгээр хүргүүлсэн хүсэлтийг тус тус хавсаргав.		
41.	5.7	Иргэний нисэхийн салбарт хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх	Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлсэн эсэх	I-IV улирал	Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төсөл, хөтөлбөрийн жагсаалт гаргаж, хөрөнгө оруулалтын	2025 онд "ИНҮТ" ТӨХХК-д хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж 2025.04.15-ны өдрийн 01-11/424 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн. "Буянт-Ухаа" ОУНБ-д ГТҮШХА-ны тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг ашиглах,	БХХАГ БТГ	30

		үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх.				эх үүсвэрийг шийдвэрлүүлэх санал боловсруулж, ТУЗ-д хүргүүлсэн байна. **II улиралд**: Хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажилласан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** 1-ээс доошгүй төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалт шийдвэрлэсэн байна.	нэмэгдүүлэх замаар агаарын хөлгийн талбайн үйлчилгээ үзүүлж, орлогыг нэмэгдүүлэх төслийг 2025.02.07-ны өдөр боловсруулсан. Энэхүү төслийн дагуу "Буянт-Ухаа" ОУНБ-д агаарын хөлөгт газрын үйлчилгээ үзүүлэх тоног төхөөрөмж, тоноглолыг нэмэгдүүлж үйлчилгээг үзүүлсэн. Хавсралт: 2025.04.15-ны өдрийн 01-11/424 дугаартай ЗТЯ-нд хүргүүлсэн /жагсаалт бүхий/ албан бичиг, "Буянт-Ухаа" ОУНБ-д ГТҮШХА-ны тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх замаар агаарын хөлгийн талбайн үйлчилгээ үзүүлж, орлогыг нэмэгдүүлэх төслийн танилцуулгыг тус тус хавсаргав.		
42.	5.8	"Жаргалант" амралтын үйл ажиллагааг өргөжүүлэх, сайжруулах.	Үйл ажиллагааг сайжруулсан эсэх	I-IV улирал	"Жаргалант" сэргээн засах амралтын амралтын үйл ажиллагааг өргөжүүлж, сувилал, сургалт, нислэгээс саатсан зорчигчдыг байрлуулах хэлбэрээр ашиглах төсөл боловсруулж, ИНЕГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1358 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд** "Жаргалант" сэргээн засах амралтын тоног төхөөрөмж, тавилгыг шинэчилсэн байна.	"Жаргалант" сэргээн засах амралтын газарт тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 3 удаа зарлаж, 2025.08.18-ны өдөр нээж, гүйцэтгэгчээр "Мөнх сора дэвшил" ХХК-тай 2025.09.22-ны өдөр гэрээ байгуулж, 2025.11.24-нд тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэх ИНҮТ/20250202034/ дугаартай гэрээг дүгнэсэн акт үйлдсэн. Тавилга, тоног төхөөрөмжийг шинэчилсэн. Хавсралт: 2025.04.29-ний өдөр баталсан "Жаргалант" сэргээн засах амралтын газарт тавилга, тоног төхөөрөмж худалдаж авах техникийн тодорхойлолт, "Мөнх сора дэвшил" ХХК-тай байгуулсан 2025.09.22-ны өдөр гэрээ, 2025.11.24-нд тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэх ИНҮТ/20250202034/ дугаартай гэрээг дүгнэсэн актыг тус тус хавсаргав.	БХХАГ ХААА	100

43.	5.9	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлыг төрийн өндөр дээд хэмжээний айлчлал хүлээн авахад зориулан тохижуулах.	Ажлын гүйцэтгэл хувиар	I-IV улирал	"Буянт-Ухаа" ОУНБ-ын барилга, авто зам, техник тоног төхөөрөмж хуучирсан.	**IV улирал:** Барилгын ажлын гүйцэтгэлийг 100 хувьд хүргэнэ.	1.Төрийн худалдан авах ажиллагааны газраас зарласан ИНҮТ/20250101007 дугаартай "Буянт-Ухаа" ОУНБ-ын дээвэр, гадна фасад, хүлээлгийн танхимын их засварын ажил төсөл, арга хэмжээний Багц-1 "Буянт-Ухаа" ОУНБ-ын дээврийн ажлыг гүйцэтгэх тендерт "Мөнх Хархираа" ХХК шалгарч, гэрээ байгуулах эрх олгогдсон. "Буянт-Ухаа" ОУНБ-ын гадна фасадын ажилд гомдол гарсан тул, хянагдаж байна. Багц-3 "Хүлээлгийн танхимын их засварын ажил" тендерт "Урал Их" ХХК шалгарсан. Засварын ажлыг 2025.06.10-ны өдрөөс 2025.09.15-ны өдөр хийж дууссан. 2."Буянт-Ухаа" ОУНБ-ын автомашины зогсоол, замын засвар тендерийн сонгон шалгаруулалтыг 2025.03.28-ны өдөр зарлаж, 2025.04.22-ны нээн үнэлж "Тэпш плант" ХХК-тай 2025.05.09-ний өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж дууссан. Хавсралт: Хүлээлгийн танхимын их засварын ажил, автомашины зогсоол, зам засварын ажлыг хүлээн авсан актуудыг хавсаргав.	ЗУГ НБҮГ ХААА	100
44.	5.10	Орон нутгийн нисэх буудлуудын нисэхийн болон нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийх.	Судалгаа хийсэн эсэх	I-II **улирал**	Анхан шатны суурь судалгааг хийж гүйцэтгэсэн	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Судалгааг хийж, дүнг "ИНҮТ" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал, ТУЗ-д танилцуулсан байна.	Орон нутгийн нисэх буудлуудын нөөц бололцоог ашиглан нисэхийн болон нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр БТГ, НБҮГ, БХХАГ-ын зүгээс хамтарч санхүүгийн судалгаа шинжилгээг хийж дууссан. Судалгаа шинжилгээг үндэслэн төсөл, хөтөлбөр боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Бат-Алдараас авах	БХХАГ	90
45.	6.1	"ИНҮТ" ТӨХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", Үйл ажиллагааны ерөнхий журмууд"-ыг	Холбогдох дүрэм, журмуудыг батлуулсан эсэх	I улирал	Холбогдох дүрэм, журмуудыг бүтэцтэй уялдуулан боловсруулах шатанд явж байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** "Хөдөлмөрийн дотоод журам", Үйл ажиллагааны ерөнхий журмууд"-ыг	Гүйцэтгэх захирлын 2025.02.07-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг баталж, нийт ажилтнуудад танилцуулан үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Гүйцэтгэх захирлын 2025.02.21-ний өдрийн А/77 дугаар тушаалаар захиргаа, санхүү, хууль, эрх зүйн чиглэлийн үйл ажиллагаанд	ЗСУГ	100

		батлуулж, мөрдөж ажиллах.				боловсруулж, батлуулсан байна. Үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж нийт 23 дүрэм, журам, заавар, бодлогын баримт бичгийг боловсруулан 2025.05.08-ны өдрийн захирлын зөвлөлийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд зөвлөлийн хуралдаанаас 31 журам, мөн компанийн харьяа 19 салбар, нэгж байгуулагдсантай холбоотойгоор салбаруудын үйл ажиллагааны журмыг боловсруулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/345 дугаар тушаалаар "Салбарын үйл ажиллагааны журам"-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.02.07-ны өдрийн А/40 дүгээр тушаал, Гүйцэтгэх захирлын 2025.02.21-ний өдрийн А/77 дугаар тушаал, 2025.05.08-ны өдрийн захирлын зөвлөлийн 4 дүгээр хуралдааны шийдвэр, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/345 дугаар тушаалыг тус тус хавсаргав.		
46.	6.2	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хүний нөөцийн стратегийн 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.	2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Иргэний нисэхийн ерөнхий газрын Хүний нөөцийн стратегийн 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө ИНЕГ-ын даргын 2024.07.31-ний өдрийн А/395 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 2024.11.20-ны өдрийн байдлаар	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьд хүргэнэ. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 50 хувьд хүргэнэ. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 70 хувьд хүргэнэ.	"ИНЕГ-ын Хүний нөөцийн стратегийг 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт 2025 оны жилийн эцсээр 86.7%-ийн хэрэгжилттэй байна. Хавсралт: "ИНЕГ-ын Хүний нөөцийн стратегийг 2024-2028 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.	ЗСУГ	70

					78.8%-ийн биелэлттэй байна.	**IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.			
47.	6.3	Иргэний нисэхийн салбарын "Хамтын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангаж, тайланг ИНЕГ-т хүргүүлэх.	Хэрэгжилт, хувиар Тайланг хүргүүлсэн эсэх	II, IV улирал	"Иргэний нисэхийн салбарт 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээр"-ийг талууд 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр дүгнэсэн. Хэрэгжилт 93.1 хувьтай.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг ЗТЯ-нд хүргүүлсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **IV улиралд:** Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг ЗТЯ-нд хүргүүлсэн байна.	"Иргэний нисэхийн салбарт 2025-2027 онд хэрэгжих хамтын хэлэлцээр" 2025.06.23-ны өдөр батлагдаж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд бүртгэгдсэн. Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэж байна. Хэрэгжилтийг 2025.12.20-нд ЗТЯ-нд хүргүүлнэ. Хавсралт: Иргэний нисэхийн салбарт 2025-2027 онд хэрэгжих хамтын хэлэлцээрийг хавсаргав.	ЗСУГ	100
48.	6.4	"Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг батлаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	"Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг баталсан эсэх, Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	I-IV улирал	Иргэний нисэхийн үндэсний төв болон түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн төслийг шинэчлэн боловсруулж, ИНҮТ-ийн даргын 2024.11.13-ны өдрийн 09-1/1285 дугаартай албан бичгээр ИНЕГ-ын ЗУХЭЗХ-т хүргүүлсэн.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** "Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулахад шаардагдах хүний нөөцийн болон нийгмийн баталгааг хангах чиглэлийн судалгаануудыг хийсэн байна. **II улиралд:** Хөтөлбөр болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. Төлөвлөгөөний	"Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг шинэчлэн боловсруулахад шаардагдах хүний нөөцийн болон нийгмийн баталгааг хангах чиглэлийн суурь судалгаануудыг шинэчилсэн. Гүйцэтгэх захирлын 2025.05.08-ны өдрийн А/299 дүгээр тушаалаар "Нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг боловсруулж, батлуулсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025.05.29-ний өдөр компанийн гүйцэтгэх захирлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 86,9%-тай байна. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025.05.08-ны өдрийн А/299 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн баталгааны хөтөлбөр", Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.	ЗСУГ	86,9

						хэрэгжилтийг 30 хувьд хүргэнэ. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Хөтөлберийн хэрэгжилт 70 хувьд хүргэнэ IV улиралд: Хөтөлберийн хэрэгжилт 90 хувьд хүргэнэ			
49.	6.5	Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх.	Төлөвлөгөө батлуулсан эсэх, Төлөвлөгөөний хэрэгжилт хувиар	II Улирал	ИНҮТ-ийн даргын 2024 оны А/162 дугаар тушаалаар ажлын хэсэг томилсон.	**Хагас жилийн байдлаар:** **1 дүгээр сард:** Төлөвлөгөө батлуулсан байна. **5 дугаар сард:** Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьд хүргэсэн байна.	Зам тээврийн яам болон Батлан хамгаалах яам хамтран 45 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 2025.02.28-ны өдөр баталсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Монгол Улсад Нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн 2025.05.19-05.25-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн. Хавсралт: Зам тээврийн яам болон Батлан хамгаалах яам хамтран 45 арга хэмжээ бүхий төлөвлөгөө, 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн тайланг тус тус хавсаргав.	Ажлын хэсэг	100
50.	6.6	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл судалгааг хөтөлж, шийдвэрлэж, тайлагнах.	Шийдвэрлэлт, хувиар Дүн шинжилгээ хийж, тайлагнасан эсэх	I-IV улирал	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 2024 оны байдлаар 95 хувьтай байна.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Шийдвэрлэлт 90 хувьд хүргэсэн байна. **II улиралд:** Шийдвэрлэлт 90 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Шийдвэрлэлт 90 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:**	Иргэд, ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, судалгааг тогтмол хийж, хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2025 оны байдлаар 1498 өргөдөл, гомдлыг ирүүлсэн ба хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 1432, шийдвэрлэх шатанд 65, хугацаа хэтэрсэн 2 өргөдөл байна. Шийдвэрлэлт 99.8%-тай байна. Өргөдөлд дүн шинжилгээ хийхэд: Хүүхдээ асрах чөлөө, тэтгэмж хүссэн тухай 47 Чөлөө хүссэн тухай 106 Шилжин ажиллахыг хүссэн тухай 164 Тэтгэмж хүссэн тухай 276 Орон сууцны хөнгөлөлтөд хамрагдахыг хүссэн тухай 38 Сургалтад хамрагдахыг хүссэн тухай 48 Ажилд орохыг хүссэн тухай 286 Ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн тухай 119	ЗСУГ	100

						Шийдвэрлэлт 90 хувьд хүргэсэн байна. Дүн шинжилгээ хийж, тайлагнасан байна.	Ээлжийн амралттай холбоотой 65 Илүү цагтай холбоотой 3 Цалингийн сүлжил, нэмэгдэлтэй холбоотой 58 Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой–9 Зайнаас ажиллахтай холбоотой 1 Тусламж 12 Бусад 254 Гомдол 12 ирүүлсэн байна. Иргэд болон ажилтнуудаас ирүүлсэн өргөдөл, гомдол хуулийн хугацаанд шийдвэрлэгддэг ба дунджаар 1 өргөдөл 4 цохолттой, шийдвэрлэх хугацаа 14 хоног байна. Нийт ирсэн өргөдөл, гомдол 4490 хуудас буюу архивын 15 боть бүрдүүлэхээр байна. Хавсралт: Өргөдөл гомдолд дүн шинжилгээ хийсэн тайланг хавсаргав.		
51.	6.7	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах.	Төлөвлөгөө батлуулсан эсэх, Хэрэгжилт, хувиар	II-IV улирал	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг 2024-2025 онд хангах төлөвлөгөөний хэрэгжилт 99%-тай.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувьд хүргэж, тайлан мэдээг ЗТЯ-д хүргүүлсэн байна.	Компанийн 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг 2025.08.04-ний өдөр баталж, харьяа салбар нэгжүүдэд хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025.12.01-ны өдрийн байдлаар 98,7%-тай байна. Хавсралт: Өвөлжилтийн батлагдсан төлөвлөгөө, /2025.08.04/ Баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.	НБҮГ Харьяа салбар нэгжүүд	98,7
52.	6.8	2025 оны гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах.	Гадаад сургалтад хамрагдсан ажилтны тоо, Төлбөртэй дотоод сургалтад хамрагдсан ажилтны тоо,	I-IV улирал	2024 онд гадаад сургалтад 188, дотоод сургалтад 768, нисэхийн сургалтын төвийн сургалтад 3227 ажилтан хамрагдсан.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Гадаад сургалтад - 25, Төлбөртэй дотоод сургалтад -40, Нисэхийн сургалтын төвд - 300	"Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн дэд захирлаар 2025 оны "Гадаад арга хэмжээний төлөвлөгөө"-г 2025.03.18-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар тэтгэлэгт сургалтад 30, хичээл, үйлдвэрлэлийн дадлага сургалтад 45, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтад 65 давхардсан тоогоор нийт 140 ажилтныг гадаад сургалтад	ЗСУГ НСТ	100

			Нисэхийн сургалтын төвд сургалтад хамрагдсан ажилтны тоо			**II улиралд:** Гадаад сургалтад-40, Төлбөртэй дотоод сургалтад -70 Нисэхийн сургалтын төвд -750 **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Гадаад сургалтад 38, Төлбөртэй дотоод сургалтад 70 Нисэхийн сургалтын төвд - 700 **IV улиралд:** Гадаад сургалтад - 40, Төлбөртэй дотоод сургалтад 70 Нисэхийн сургалтын төвд -650	хамруулж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулсан. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлаар "2025 онд зохион байгуулагдах төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г 2025.05.07-ны өдөр батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар 77 сургалтад 545 ажилтан хамруулсан. "Нисэхийн сургалтын төвд 2025 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөө"-г 2025.01.14-ний өдөр гүйцэтгэх захирлаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 40 сургалтад 2601 суралцагч, захиалгат 26 сургалтад 431 суралцагч нийт 66 сургалтад 3032 ажилтныг хамруулсан. Хавсралт: 2025.03.18-ны өдөр батлуулсан. "Гадаад арга хэмжээний төлөвлөгөө", Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилт, 2025.05.07-ны өдөр батлагдсан "2025 онд зохион байгуулагдах төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө" , Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилт, 2025.01.14-ний өдөр батлагдсан "Нисэхийн сургалтын төвд 2025 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөө", Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.		
53.	6.9	ICAO-аас баталгаажсан стандартчилагдсан сургалтын багц (ITP, STP) хөтөлбөрийн сургалтуудыг Нисэхийн сургалтын төвд зохион байгуулж,	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-IV улирал	2024 онд НСТ-д ICAO-аас баталгаажсан стандартчилагдсан сургалтын багц (ITP, STP) хөтөлбөрийн сургалтуудыг 100%-ийн	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **IV улиралд:**	"Нисэхийн сургалтын төвийн 2025 оны орлого, зардлын төлөвлөгөө"-г 2025.04.24-ний өдөр батлуулсан бөгөөд Trainair plus хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтуудын зардал батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулах хүсэлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-д хүргүүлж, зөвшөөрөл авсны дагуу амжилттай зохион байгуулаад байна. Үүнд:	ЗСУГ НСТ	98,3

		хүний нөөцийг дотооддоо мэргэшүүлэх.			гүйцэтгэлтэй зохион байгуулсан.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьд хүргэсэн байна.	1. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/334 дугаар тушаалаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын стандартчилагдсан сургалтын багц хөтөлбөрийг заах багшийг бэлтгэх -"Training Instructor Course" 212/002/TIC EN олон улсын сургалтыг 2025.06.09-өөс 13-ны өдрүүдэд зохион байгуулж, ICAO-ийн сургалт заах эрхтэй 10 багшийг бэлтгэв. 2. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/416 дугаар тушаалын дагуу ICAO-ийн виртуал хичээлийг удирдан явуулахад шаардлагатай ур чадварыг багшид олгох "Virtual Classroom Instruction" (VCI EN ITP/TCD/VCI VC/031 EN) олон улсын сургалтыг 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдөр НСТ-өөс зохион байгуулж, 13 багшийг ICAO-ийн виртуал хичээл заах эрхтэй болгон бэлтгэв. 3. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/419 дүгээр тушаалаар ICAO-ийн иргэний нисэхийн стандартчилагдсан сургалтын хөтөлбөр боловсруулах ур чадвар олгох "Training Developers Course" 214/001/TDC EN олон улсын сургалтыг 2025.08.11-ээс 22-ны өдрүүдэд зохион байгуулж, 15 сургалтын хөтөлбөр боловсруулагчийг бэлтгэв. 4. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/453 дугаар тушаалаар Австрали Улсын "Aviation Rescue Services Pty Ltd" сургалтын байгууллагаас "Чингис хаан" олон улсын нисэх буудалд 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулсан "Aircraft Rescue & Fire Fighting (ARFF) training" олон улсын сургалтад "Буянт-Ухаа" Олон улсын		

							нисэх буудлын 3 ажилтныг хамруулж, Агаарын хөлгийн аврах, гал унтраах багшийг бэлтгэв. 5. ИНЕГ-ын захиалгаар дараах 2 сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлын бүрэн ханган ажилласан. Үүнд: Мөн Safety Management System Assessment and Monitoring (SMSAM EN) сургалтыг 2025.09.28-10.01-ний өдрүүдэд зохион байгуулж, 16 байцаагчийг гэрчилгээжүүлэв. USOAP CMA Phase 2 - Aircraft Accident and incident Investigation (AIG EN) сургалтыг зохион байгуулах эрхийг ICAO-аас авч, бэлтгэл ажлыг ханган ажилласан боловч ИНЕГ-ын ажилтнууд суралцагчдад тавигдах шаардлагыг хангаж чадаагүй тул цуцлагдсан. "ИНҮТ" ТӨХХК-ийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн хүсэлтийн дагуу Airport Pavement Strength Rating (APSR EN) Virtual Classroom ITP/AGA/109/APSR VC/055EN сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/607 дугаар тушаалын дагуу зохион байгуулж, 10 мэргэжилтнийг хамруулав. 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 98,3%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт: Trainair plus хөтөлбөрийн хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилт, сургалтын тушаалуудыг тус тус хавсаргав.		
54.	6.10	"ИНҮТ" ТӨХХК-ийн харьяа салбар, нэгжийн ажилтнуудыг олон улсын тэтгэлэгт сургалтад хамруулах үйл	Хамруулсан тэтгэлэгт хөтөлбөрийн тоо, Хамрагдсан ажилтны тоо	I-IV улирал	2024 онд 14 тэтгэлэгт сургалтад 27 ажилтан материал ирүүлсэн бөгөөд 7 сургалтад 7 ажилтан тэнцэж,	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Зарласан тэтгэлгийн тоо - 7 **Жилийн эцсийн байдлаар:** **IV улиралд:**	Зарласан тэтгэлгийн тоо – 20 Нисэхийн сургалтын төв нь Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас хөгжиж буй орнуудад зориулсан нийт богино хугацааны 14, магистрын 6 тэтгэлэгт хөтөлбөрийн мэдээллийг "ИНҮТ" ТӨХХК-ийн нийт ажилтнуудад tc.ncac.mn болон ncac.mn вэб хуудас, root mail-ээр хүргүүлсэн.	ЗСУГ НСТ	100

		ажиллагааг нээлттэй, үр дүнтэй зохион байгуулах.			сургалтад хамрагдсан байна.	Зарласан тэтгэлгийн тоо - 7	✓ Бүгд Найрамдах Сингапур Улс болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас хөгжиж буй орнуудын сургалтын хөтөлбөр; ✓ БНСУ-ын Засгийн газар болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын хамтарсан хөгжиж буй орнуудад зориулсан 2025 оны тэтгэлэгт сургалт; ✓ Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) болон Испанийн хаант улсын Агаарын навигацийн бизнесийн сургууль (ITAérea Aeronautical Business School)-аас хамтран хэрэгжүүлж буй хөгжиж буй орнуудад зориулсан 2025 оны тэтгэлэгт сургалт; ✓ Бүгд Найрамдах Солонгос Улсын Сансар судлалын их сургуулийн магистрын тэтгэлэгт хөтөлбөр. ✓ Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар болон Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-аас хамтран зарласан "Next Generation Aviation Professionals" тэтгэлэгт хөтөлбөр; Зарлагдсан 20 тэтгэлэгт сургалтуудад нийт 16 ажилтны танилцуулах хуудас, nomination form болон бусад шаардлагатай баримт бичгийн боловсруулалтыг хийж ИНЕГ-ын даргаар батлуулж, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 2 ажилтан тэтгэлэгт сургалтад тэнцээд байна. Хавсралт: Зарласан тэтгэлийн зар, албан бичиг, тэтгэлэгт сургалтад хамрагдсан 2 ажилтны гэрчилгээг тус тус хавсаргав.		
55.	6.11	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	I-II улирал	Зам тээврийн сайдын 2024.12.16-ны өдрийн А/273-р тушаалаар Ажлын хэсэг байгуулсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Зам, тээврийн сайдын 2024 оны А/273 дугаар тушаалын	Зам, тээврийн сайдын 2024.12.16-ны өдрийн А/273 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн удирдамжид тусгагдсаны дагуу Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:	ЗСУГ	100

						хавсралтаар баталсан удирдамжид тусгагдсан ажлууд хэрэгжсэн байна. Хэрэгжилт 90%-д хүрсэн байна.	1. Зам тээврийн сайдын 2024.12.27-ны өдрийн А/290 дүгээр тушаалаар "ИНҮТ" ТӨХХК-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц орон тоог баталсан ба Шатахуун хангалтын албыг "Эрчис ойл" ТӨХК-д шилжүүлсэнтэй холбогдуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.05.29-ний өдрийн шийдвэрээр зохион байгуулалтын бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. 2. Хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан захирлын зөвлөлийн 2025.05.08-ны өдрийн 4 дүгээр хуралдааны шийдвэрээр 31 дүрэм, журам, заавар, бодлогын баримт бичгийг боловсруулан батлаж, мөрдөн ажиллаж байна. 3. Хуулийн шинэчлэлтээр "Иргэний нисэхийн үндэсний төв" нь Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын балансаас барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг шилжүүлэн авах ажлын хүрээнд "Тооллогын комисс"-ыг байгуулж, хөрөнгийн тооллого хийж, нэгдсэн тайланг компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, 2025.06.03-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн. 4."ИНҮТ" ТӨХХК, түүний харьяа нийт 19 салбар нэгжүүдийн гэрчилгээ тэмдгийг Улсын бүртгэлийн ерөнхий газар, аймгийн Улсын бүртгэлийн газруудад бүргүүлж, гэрчилгээ тэмдгийг шинээр авсан. Хэрэгжилт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт: Зам, тээврийн сайдын 2024.12.16-ны өдрийн А/273 дугаар тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.05.29-ний өдрийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.05.08-ний өдрийн 01 дугаар шийдвэр, ИНЕГ-т 2025.06.03-ны өдрийн 02-9/760 дугаартай албан бичиг,		

							Гүйцэтгэх захирлын 2025.06.09-ний өдрийн А/345 дугаар тушаал, Гүйцэтгэх захирлын 2025.08.21-ний өдрийн А/481 дүгээр тушаалыг тус тус хавсаргав.		
56.	6.12	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, тайлагнах.	Хяналт тавьж, хугацаандаа тайлагнасан эсэх	I-IV улирал	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж тогтмол мэдээллийг вэб хуудсанд байршуулдаг.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хугацаандаа тайлагнасан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хугацаандаа тайлагнасан байна.	Гүйцэтгэх захирлын 2025 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/201 дүгээр тушаал, "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээ байршуулах үүргийг шилжүүлэх тухай" А/350 дугаар тушаалаар батлагдсан Компанийн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах албан тушаалтан, түүний гүйцэтгэх чиг үүрэг, ажлын хуваарийн дагуу тус газрын нэгжүүдээс 15 нэр төрлийн мэдээ, мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулан ажилласан бөгөөд нийт 157 мэдээлэл байршуулахаас 2025.12.01-ний өдрийн байдлаар 141 мэдээллийг хугацаандаа мэдээлж, хугацаа болоогүй 14 ба хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Үүнд: Хугацаа хоцорч мэдээлсэн төлөвтэй мэдээлэл нь "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээлэх хуулийн хугацаатай боловч уг төлөвлөгөө нь компанийн бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор 2025.01.28-ны өдөр батлагдсаныг 2025.01.29-ний өдөр шилэн дансны цахим системд ил тодоор мэдээлсэн. Хугацаа хоцорч мэдээлсэн төлөвтэй дараагийн мэдээлэл нь "Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт" гэсэн сарын мэдээг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээлэх хуулийн хугацаатай боловч мэдээлэл оруулах эдийн засагч нь ээлжийн амралттай хугацаанд мэдээллийг хоцорч оруулсан.	ЗСУГ ДАА ХААА	100

							Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/201 дүгээр тушаал, Гүйцэтгэх захирлын "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээ байршуулах үүргийг шилжүүлэх тухай" А/350 дугаар тушаалуудыг тус тус хавсаргав.		
57.	7.1	ИНҮТ-ийн хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хуулийн хугацаанд хэрэгжүүлэх.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан эсэх, Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2025.03.01-ний өдрийн дотор зохион байгуулсан эсэх, Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	II-IV улирал	2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай.	**Хагас жилийн байдлаар:** **I улиралд:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан байна. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2025.03.01-ний өдрийн дотор зохион байгуулсан байна. **II улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилт 30 хувьд хүргэсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьд хүргэсэн байна. **IV улиралд:** Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьд хүргэсэн байна.	Тайлант хугацаанд нийт 2 удаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.01.28 өдөр "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Мөн гүйцэтгэх захирлын 2025.09.17-ны өдрийн А/525 дугаартай тушаалаар "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөг баталсан. 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар тус төвд нийт 185 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулж байна. Үүнд: 1. Нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар - **18** /ТБОНӨХБАУХАТХ-ийн 36 дугаар зүйлийн 36.1.1, 3.1.6 дахь заалт/ 2. Нээлттэй болон харьцуулалтын тендер шалгаруулалтын аргаар тендер зарлах - **114** 3. Орон нутгийн салбарын удирдлагуудад итгэмжлэн шилжүүлсэн **53** төсөл арга хэмжээ "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн" 31 дүгээр зүйлд заасан тендер шалгаруулалтын аргаар төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендеруудийг давхардсан тоогоор 212 удаа зарласан байна. Үүнд: Үнэлгээний хорооны тушаал гарсан 128, тендер хүлээн авч байгаа 16, тендер нээн үнэлж байгаа 12, гэрээ байгуулах эрх	ЗСУГ	77.4

							олгосон 8, гэрээ байгуулсан 70 арга хэмжээ байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 77,4%-тай байна. Хавсралт: 2025.01.28-ны өдөр баталсан "2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө", 2025.09.17-ны өдрийн А/525 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан төлөвлөгөө, Гүйцэтгэх захирлын 2025.01.28-ны өдрийн 01/94 дугаар албан бичгийг тус тус хавсаргав.		
58.	7.2	ИНҮТ болон харьяа салбар, нэгжийн эд хөрөнгийн эзэмшил ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавьж, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.	Хөрөнгийн бүртгэл иж бүрэн, үнэн зөв бүртгэгдсэн эсэх, Тайланг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д танилцуулж, шийдвэр гаргуулсан эсэх	II-IV улирал	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлэхээр үүрэг болгосон.	**Хагас жилийн байдлаар:** **II улиралд:** Ажлын хэсэг томилогдсон байна. Хөрөнгийн тооллого хийж, тайланг нэгтгэсэн байна. Үр дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлнэ. **Жилийн эцсийн байдлаар:** **III IV улиралд:** Үр дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулж, шийдвэр гаргуулна.	Гүйцэтгэх захирлын 2025.03.28-ны өдрийн А/158 дугаар тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулсан. ба тайлант хугацаанд уг зөвлөлийг 2 удаа хуралдуулан, компанийн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой шийдвэрийг гаргаж ажилласан. 1.Шатахуун хангалтын албыг "Эрчис ойл" ТӨХХК-д шилжүүлэхтэй холбоотой Шатахуун хангалтын албанд бүртгэлтэй хөрөнгийн жагсаалтыг гаргах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын 2025 оны А/120 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2025.03.31-ний өдөр Өмч хамгаалах байнгын зөвлөлд тайланг танилцуулж, уг зөвлөлийн шийдвэрийн дагуу Гүйцэтгэх захирлын 2025 оны "Шатахуун хангалтын албыг шилжүүлэхтэй холбоотой зарим арга хэмжээг авах тухай" А/161 дүгээр тушаал гарсан. 2."Иргэний нисэхийн үндэсний төв" нь Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болж өөрчлөн байгуулагдсантай холбоотойгоор хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг гүйцэтгэх захирлын 2025 оны А/224 дүгээр тушаалаар байгуулсан. Тооллогын комисс компанийн хэмжээнд тооллогыг зохион байгуулж, салбар, нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэсэн ба тайланг 2025.05.30-ны өдөр Өмч хамгаалах	ЗСУГ	100

							байнгын зөвлөлд танилцуулж, 2025.06.03-ны өдрийн 02-9/760 дугаартай албан бичгээр Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлсэн. ИНЕГ-ын даргын А/205 тоот "Балансаас балансад хөрөнгө, ер төлбөр, эздийн өмч шилжүүлэх тухай" тушаалаар үндсэн хөрөнгөөс бусдыг шилжүүлэх шийдвэр гарсан. Мөн ТӨБЗГ-ын 2025.09.25-ны өдрийн "Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай" 438 дугаар тогтоол гарсан. Хавсралт: Гүйцэтгэх захирлын 2025 оны А/120 дугаар тушаал, Гүйцэтгэх захирлын 2025.03.28-ны өдрийн А/158 дугаар тушаал, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/161 дүгээр тушаал, Гүйцэтгэх захирлын 2025 оны А/224 дүгээр тушаал, Гүйцэтгэх захирлын 2025.06.03-ны өдрийн 02-9/760 дугаартай албан бичиг, ИНЕГ-ын даргын 2025 оны А/205 дугаар тушаал, ТӨБЗГ-ын 2025.09.25-ны өдрийн 438 дугаар тогтоолыг тус тус хавсаргав.		
59.	7.3	Өр авлагыг барагдуулах.	Өр, авлага бууралт, хувиар	I-IV улирал	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар үүрэг болгосон.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Өр, авлагыг 2 хувиар бууруулсан байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Өр, авлагыг 3 хувиар бууруулсан байна.	"ИНҮТ" ТӨХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2025.01.01-ний өдрийн авлагын эхний үлдэгдэл 9.2 тэрбум төгрөг, өглөгийн эхний үлдэгдэл 222.45 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба компанийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/224 дүгээр тушаалаар байгуулагдсан Тооллогын комиссын тайланд мөн оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар авлагын үлдэгдэл 9.9 тэрбум төгрөг, өглөгийн үлдэгдэл 1.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зорилтот түвшинд зөвхөн үйл ажиллагааны авлагыг тусгасан ба үйл ажиллагааны авлагыг 7,6 тэрбумаар төгрөгөөр тогтоосон ба 12 сарын 15-ны өдрийн байдлаар нийт	ЗСУГ	100

							авлага 12,8 тэрбум төгрөг байгаагаас үйл ажиллагааны авлага 7,1 тэрбум төгрөг буюу 6,5% барагдуулсан ба 4,5 тэрбум төгрөг нь Хөрөнгө оруулалтын ажлуудын явцаас хамааран гүйцэтгэлээр олгож байгаа үе шатны санхүүжилтүүд авлагаар бүртгэгдсэн. Мөн дотоодын агаарын тээвэрлэгчдийн хуримтлагдсан авлагыг гэрээний дагуу өдөр бүрийн төлөлт хийж байгаа ба НАБХА-ны Зорчигч үйлчилгээний хураамжийн орлогын НӨАТ-н асуудал болох 1,2 тэрбум төгрөгийн эцэслэн шийдэгдээгүй байгаатай холбоотой. "Өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөө"-г Хууль, эрх зүйн газартай хамтран боловсруулан, холбогдох удирдлагуудад танилцуулан Захиргаа, санхүү хариуцсан ерөнхий менежерээр батлуулан мөрдөн ажиллаж байна. Удаашралтай байгаа авлагын судалгааг гарган холбогдох материал, мэдээллийг цуглуулан ЗХЭЗХ-тэй хамтран ажиллаж байна. Зорилтот түвшинд зөвхөн үйл ажиллагааны өглөгийг тусгасан ба үйл ажиллагааны өглөгийг 597,39 сая төгрөгөөр тогтоосон ба 12 сарын 15-ны өдрийн байдлаар нийт өглөг 5,1 тэрбум төгрөг байгаагаас үйл ажиллагааны өглөг 575 сая төгрөг буюу 3,7% барагдуулсан. Хөрөнгө оруулалтын ажлуудын барьцааг 12 сарын хугацаанд авч үлдэж байгаа 1,1 тэрбум төгрөг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тооцооллыг дараа жил нь хийж өмнөх онд өглөг үүсгэдэгтэй холбоотойгоор 2025 оны 3 улирлын байдлаар 17 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан тул Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өглөг 3,5 тэрбум төгрөгийн тооцоо үүсснээс 2 тэрбумыг төлж барагдуулсан болно.		

							Дээрх үйл ажиллагааны авлага, өглөгийг жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулах бөгөөд жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар бүрэн илэрхийлэгдэх болно. Хавсралт: ЗСУГ-ын даргын 2025.06.02-нд батлсан "Өр авлага барагдуулах ажлын төлөвлөгөө", СННБХ-ээс ЗХЭЗХ-ийн хуулийн мэргэжилтэнд хүргүүлсэн "Насжилт өндөр , удаашралтай авлагуудын жагсаалт", Төлөвлөгөөний баталгаажсан хэрэгжилтийг тус тус хавсаргав.		
60.	7.4	ИНҮТ-ийн харьяа алба салбаруудын үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх ажлыг хийх.	Хийгдсэн судалгаа, өөрчлөгдсөн тарифын тоо, Орлого нэмэгдсэн эсэх	I-IV улирал	Харьяа алба салбаруудын үйлчилгээний төрөл, тариф батлагдсан.	**Хагас жилийн байдлаар:** **I-II улиралд:** Үйлчилгээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, орлого нэмэгдүүлэх судалгаа хийж, орлого нэмэгдүүлэх ажил хийсэн байна. **Жилийн эцсийн байдлаар:** **III-IV улиралд:** Орлогын төрлийг нэмэгдүүлж, орлого өссөн байна.	Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй үйлчилгээний төрөл, тарифын судалгааг нэгтгэн гаргаж, орлого нэмэгдүүлэх боломжийг судалж эхэлж байсан боловч МУ-ын ЗГ-ын 2025 оны 132 дугаар тогтоолын дагуу төрөөс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байхыг зөвлөсний дагуу тариф нэмэгдүүлэх ажлыг зогсоосон. ЗТЯ-ны сайдын 2025.10.14-ний өдрийн А/278 дугаар тушаалаар агаарын навигацийн аэродромын үйлчилгээний хураамжийн үнэлгээг тогтоож, батлснаар ЧХОУНБ болон БУОУНБ-уудад нислэг үйлдэх агаарын хөлөгт үзүүлж буй агаарын навигацийн аэродромын үйлчилгээний хураамжийг авдаг болсноор орлогын эх үүсвэр нэмэгдсэн. Хавсралт: "ИНҮТ" ТӨХХК-ийн харьяа салбар нэгжийн үйлчилгээний тарифийн судалгаа, ЗТЯ-ны сайдын 2025.10.14-ний өдрийн А/278 дугаар тушаал, МУЗГ-ын 2025 оны 132 тугаар тогтоолыг тус тус хавсаргав.	БТГ	90

Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Үүнээс																	Дундаж хувь
		Хувь	30	38.7	50	70	72.5	75	77.4	80	86.9	90	91.5	95	95.4	98.3	98.5	98.7	100	
7	60	Тоо	2	1	1	4	1	1	1	2	1	3	1	1	1	1	2	1	36	90.77%

Үр дүн	Тоо	Хувь
Үр дүн гарсан	47	98.57%
Үр дүнгүй	13	62.58%

Хэрэгжилтийн дунджийг үр дүн тус бүрээр тооцов.

ХЯНАСАН:
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Э.НАРАНТУНГАЛАГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР Ч.ШҮРЭНХҮҮ

ЗСУГ-ЫН ХЭЗХ-ИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.НАНЖИД